

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2026/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум

2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren.p.audit@gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: Chadvarlagaudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг: sosorburampurev3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.03 № 56

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Тавдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Тавдугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 88.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 11.6 сая төгрөг, хандив тусламжаар 5.3 сая төгрөг, нийт 105.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна. Тайлант онд 8 хөтөлбөр арга хэмжээнд 821.3 сая төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 97.0 хувьтай байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд улсын төсвөөс 821.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 73.0 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Жилийн эцэст 41.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

6225020126

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт төсөл, 65 арга хэмжээ төлөвлөж 90.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>212,129,999.17</b>	<b>94,918,429.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	150,521,169.17	41,290,018.30
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	150,521,169.17	41,290,018.30
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	150,521,169.17	41,290,018.30
31211	Төрийн сангийн харилцах	150,521,169.17	41,290,018.30
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	36,437.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	36,437.39
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	61,608,830.00	53,591,974.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	655,000.00	655,000.00
35130	Эм боох материал	655,000.00	655,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	60,953,830.00	52,936,974.00
35410	Бичиг хэргийн материал	68,000.00	30,000.00
35420	Аж ахуйн материал	2,831,000.00	3,047,900.00
35460	Хүнсний материал	5,984,110.00	2,528,430.00
35470	Бусад хангамжийн материал	52,070,720.00	47,330,644.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>455,174,612.43</b>	<b>539,825,116.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	455,174,612.43	539,825,116.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	363,894,612.43	448,725,116.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	472,706,877.53	561,556,877.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,892,168.16)	(166,174,920.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,455,881.85	101,222,913.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,860,073.44)	(64,498,827.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,524,121.52	24,671,628.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,141,693.67)	(8,197,553.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,330,000.00	4,330,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,373,333.20)	(4,330,000.00)
39217	Ном	145,000.00	145,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	91,280,000.00	91,100,000.00
39301	Програм хангамж	1,390,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(910,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,800,000.00	90,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>667,304,611.60</b>	<b>634,743,546.65</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>667,304,611.60</b>	<b>634,743,546.65</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	667,304,611.60	634,743,546.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	234,421,810.20	234,421,810.20
51101	Өмч: - төрийн	234,421,810.20	234,421,810.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	131,962,427.91	99,401,362.96
51210	Өмнөх үеийн үр дүн	81,405,951.61	131,962,427.91
51220	Тайлант үеийн үр дүн	50,556,476.30	(32,561,064.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	300,920,373.49	300,920,373.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>667,304,611.60</b>	<b>634,743,546.65</b>

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>972,958,050.00</b>	<b>1,007,114,800.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>14,341,250.00</b>	<b>112,783,600.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	14,341,250.00	112,783,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,341,250.00	110,596,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,187,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>958,616,800.00</b>	<b>894,331,200.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	886,659,300.00	821,323,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	886,659,300.00	821,323,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,957,500.00	73,007,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,957,500.00	73,007,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>922,401,573.70</b>	<b>1,039,675,864.95</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>922,401,573.70</b>	<b>1,039,675,864.95</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,871,366.70	1,027,612,656.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,112,001.00	727,947,394.53
210101	Үндсэн цалин	407,515,730.20	465,005,597.13
210102	Нэмэгдэл	171,795,110.00	203,008,587.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	23,737,244.00
210104	Урамшуулал	30,801,160.80	36,195,966.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,165,501.54	89,217,216.95
210201	Тэтгэврийн даатгал	51,223,302.86	60,986,679.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,111,570.13	7,342,031.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,049,185.69	3,623,560.14
210204	Ажилгүйдлийн даатгал	2,756,288.08	3,465,274.84
210205	Эрүүл мэндийн даатгал	11,025,154.78	13,799,670.97
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,841,593.00	56,299,552.00
210301	Гэрэл, цахилгаан	6,067,484.00	7,167,189.00
210302	Түлш, халаалт	41,854,983.00	41,854,983.00
210303	Цэвэр, бохир ус	4,919,126.00	7,277,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,069,234.00	13,913,676.00
210408	Бараа материал ақталсны зардал	7,069,234.00	13,913,676.00
2105	Нормативт зардал	81,027,883.00	70,617,780.00
210502	Хоол, хүнс	81,027,883.00	70,617,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,670,000.00	8,999,940.00
210604	Урсгал засвар	16,670,000.00	8,999,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,747,200.00	4,351,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,747,200.00	4,351,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,237,954.16	56,266,097.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,590,500.00	10,190,102.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,381,245.00	8,452,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,266,209.16	37,623,495.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,530,207.00	12,063,208.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,414,300.00	4,355,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,414,300.00	4,355,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,115,907.00	7,708,008.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,115,907.00	7,708,008.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>50,556,476.30</b>	<b>(32,561,064.95)</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>50,556,476.30</b>	<b>(32,561,064.95)</b>

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>958,616,800.00</b>	<b>894,331,200.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>958,616,800.00</b>	<b>894,331,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	886,659,300.00	821,323,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	886,659,300.00	821,323,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	71,957,500.00	73,007,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,957,500.00	73,007,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>876,243,687.54</b>	<b>991,884,350.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>876,243,687.54</b>	<b>991,884,350.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>863,713,480.54</b>	<b>979,821,142.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	610,112,001.00	727,983,831.92
210101	Үндсэн цалин	407,515,730.20	465,042,034.52
210102	Нэмэгдэл	171,795,110.00	203,008,587.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	23,737,244.00
210104	Урамшуулал	30,801,160.80	36,195,966.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,165,501.54	89,217,216.95
210201	Тэтгэврийн даатгал	51,223,302.86	60,986,679.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,111,570.13	7,342,031.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,049,185.69	3,623,560.14
210204	Ажилгүйдлийн даатгал	2,756,288.08	3,465,274.84
210205	Эрүүл мэндийн даатгал	11,025,154.78	13,799,670.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,841,593.00	56,299,552.00
210301	Гэрэл, цахилгаан	6,067,484.00	7,167,189.00
210302	Түлш, халаалт	41,854,983.00	41,854,983.00
210303	Цэвэр, бохир ус	4,919,126.00	7,277,380.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	80,139,940.00	67,162,100.00
210502	Хоол, хүнс	80,139,940.00	67,162,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,000,000.00	8,999,940.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	8,999,940.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлөөр, хувьцаа</b>	2,747,200.00	4,351,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,747,200.00	4,351,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	28,707,245.00	25,807,502.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,293,000.00	17,749,302.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,414,245.00	8,058,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,530,207.00</b>	<b>12,063,208.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,414,300.00	4,355,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,414,300.00	4,355,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,115,907.00	7,708,008.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,115,907.00	7,708,008.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>82,373,112.46</b>	<b>(97,553,150.87)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,608,000.00</b>	<b>11,678,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,608,000.00</b>	<b>11,678,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,608,000.00	11,678,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,608,000.00	11,678,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,608,000.00)</b>	<b>(11,678,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	79,765,112.46	(109,231,150.87)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	70,756,056.71	150,521,169.17
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	150,521,169.17	41,290,018.30

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*төгрөгөөр*

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	81,405,951.61	616,748,135.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	81,405,951.61	616,748,135.30
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	131,962,427.91	667,304,611.60
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	131,962,427.91	667,304,611.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	131,962,427.91	667,304,611.60
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(32,561,064.95)	(32,561,064.95)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	99,401,362.96	634,743,546.65

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*төгрөгөөр*

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,029,558,100.00	1,003,562,350.87	25,995,749.13	97.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,029,558,100.00	1,003,562,350.87	25,995,749.13	97.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,025,202,900.00	991,499,142.87	33,703,757.13	96.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	734,900,300.00	727,983,831.92	6,916,468.08	99.1
210101	Үндсэн цалин	477,966,100.00	465,042,034.52	12,924,065.48	97.3
210102	Нэмэгдэл	229,149,600.00	203,008,587.00	26,141,013.00	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	23,737,244.00	-	-
210104	Урамшуулал	27,784,600.00	36,195,966.40	(8,411,366.40)	130.3
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	91,378,600.00	89,217,216.95	2,161,383.05	97.6
210201	Тэтгэврийн даатгал	61,983,200.00	60,986,679.50	996,520.50	98.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,348,400.00	7,342,031.50	6,368.50	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,674,500.00	3,623,560.14	50,939.86	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,674,500.00	3,465,274.84	209,225.16	94.3
210205	Эрүүл мэндийн даатгал	14,698,000.00	13,799,670.97	898,329.03	93.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	64,007,500.00	56,299,552.00	7,707,948.00	88.0
210301	Гэрэл, цахилгаан	11,700,000.00	7,167,189.00	4,532,811.00	61.3
210302	Түлш, халаалт	41,857,500.00	41,854,983.00	2,517.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	10,450,000.00	7,277,380.00	3,172,620.00	69.6
210304	Байрны түрээс	-	-	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	82,731,700.00	67,162,100.00	15,569,600.00	81.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	82,731,700.00	67,162,100.00	15,569,600.00	81.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,000,000.00	8,999,940.00	60.00	100.0
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,999,940.00	60.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,361,800.00	4,351,000.00	10,800.00	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,361,800.00	4,351,000.00	10,800.00	99.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,823,000.00	37,485,502.00	1,337,498.00	96.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,764,800.00	29,427,302.00	1,337,498.00	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,058,200.00	8,058,200.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,355,200.00	12,063,208.00	(7,708,008.00)	277.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,355,200.00	4,355,200.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,355,200.00	4,355,200.00	-	100.0
<b>26</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	-	7,708,008.00	(7,708,008.00)	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,708,008.00	(7,708,008.00)	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>150,521,169.17</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>41,290,018.30</b>		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил<sup>1</sup> илэрч 2 албан шаардлага өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

#### 3.2 Албан шаардлага

##### 1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн Б/13 тоот тушаалаар нягтлан бодогчид 1.559.0 мянган төгрөгийн, няравт 1.105.0 мянган төгрөгийн 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нийт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

##### 2. Илрүүлэлт

Шилэн дансны сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 5,231.8 мянган төгрөгийн зарлагыг, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 17,824.4 мянган төгрөгийн орлогын мэдээлэл байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээллийн 89.6 хувь байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

хамт 2026 оны 05 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

**3.3 Зөвлөмж**

Зөвлөмж бичигдээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Т	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			о	о	о	о	о	о	о	о	о	о	о
Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн Б/13 тоот тушаалаар нягтлан бодогчид 1.559.0 мянган төгрөгийн, няравт 1.105.0 мянган төгрөгийн 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нийт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	1	2,664.0			1	2,664.0							

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 5,231.8 мянган төгрөгийн зарлагыг, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 11,824.4 мянган төгрөгийн орлогын мэдээлэл байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээллийн 89.6 хувь байршуулсан .	1	17,058.3			1	17,058.3		

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Дүн	1	17,058.3			1	17,058.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
2026 оны 02 дугаар сарын 23